



**BASALTWOOL®**  
**МОНГОЛ БАЗАЛЬТ ХХК**



**BASALTWOOL®**

Ногоон ургамал, хөрсгүй тариалалт BASALTWOOL

Үрсэлгээний шоо

Ургуулах блок

Үрсэлгээний хавтан

Үйрмэг хөвөн

Иж бүрэн багц

# Ногоон ургамал, хөрсгүй тариалалт BASALTWOOL

## BASALTWOOL брендиийн Rockwool бүтээгдэхүүнүүд:

- Үрсэлгээний шоо
- Ургуулах блок
- Үрсэлгээний хавтан
- Үйрмэг хөвөн
- Иж бүрэн багц

Базалт болон шохойн чулууны байгалийн найрлагаас гаргаж авсан BASALTWOOL чулуун хөвөнг хүлэмжинд ургамал үржүүлэх орчин болгон ашигладаг. 1600°C-д хайлуулсан хайлмагийг “хөөсөн чихэр” мэт шөрмөслөг болгон, тасралтгүй ажиллагаатай конвейрын тусламжтайгаар хөвөн суулгах камерт оруулна. Хэрэв та хэзээ нэг цагт галт уулыг үзсэн бол үүнтэй адил шөрмөслөгүүдийг галт уулын эргэн тойронд агаарт нисч байхыг харсан байж магадгүй. Шөрмөслөгүүдийг хөвөн болгон суулгаж, дараа нь дэвсгэр болгон шахаад тэдгээрийг хавтангуудад хуваана. BASALTWOOL-ийн ширхэгүүд нь шахадаагүй шөрмөслөгийн багц юм. Боловсруулалт маш үр дүнтэй, 1 куб фут чулуунаас 37 куб фут хөвөн үйлдвэрлэнэ. BASALTWOOL нь маш халуун нөхцөлд үйлдвэрлэгдэх байгаа тул бүтээгдэхүүн нь хими биологийн шинж чанараараа идэвхигүй бөгөөд хөрсгүй ургамал ургуулах технологийн хувьд төгс орчин болж чадна. Данид энэхүү технологи 1970-аад онд үүссэн үеэс эхлэн BASALTWOOL брендиийн Rockwool-ийг Европ болон Хойд америк даяар хүнсний ногоо болон цэцэг үржүүлэлтийн үндсэн орчин болгон ашигласаар ирсэн.



Хүлэмжийн орчинд хэрэглэх BASALTWOOL брендиийн Rockwool хоёр үндсэн хэлбэртэй байдаг. Эхнийх нь шөрмөслөгүүд нь хоорондоо наалдсан буюу холбогч ашиглан хатуу болгосон уян бус хавтан, блок шоонууд юм. Энэ нь ургамал, цэцгийн аж үйлдвэрт хэрэглэгдэх анхдагч хэлбэр юм. Хоёрдугаарт, өндөр хэмжээнд цэвэршуулсан, тогтвортой гидрофил болон гидрофоб буюу ус шингээгч болон ус үл нэвтрүүлэх шинж чанартай үйрмэг хөвөн хэлбэрийн Rockwool орно. Энэ хэлбэрийг олон төрлийн хүлэр намаг бүхий хөрсгүй орчин мөн хүнд шавар, хөнгөн элсэргэх хөрсний орчинг сайжруулахад ашиглана.

Дээрхи бүтээгдэхүүнүүд нь төрөл бүрийн хэрэглээнд ашиглаж болохуйцаар олон хэлбэр, хэмжээтэй байна. Бид ургуулах, үрслүүлэх ажилд зориулж олон янзын хэмжээтэй шоо, блок, хавтангууд санал болгодог. Бүх BASALTWOOL брендиийн Rockwool бүтээгдэхүүний хамгийн чухал шинж чанар бол тариалагчидад ургамлын үрслэх орчны өөрчлөлтийг түргэн мэдэрч шаардлагатай өөрчлөлтийг хийх боломж олгодогт оршино. BASALTWOOL брендиийн Rockwool нь ургамал ургуулах идэвхигүй орчин болж чаддаг. Учир нь BASALTWOOL брендиийн Rockwool-ийн шөрмөслөгүүд нь ургамалд орж буй шим бодисын найрлагыг өөрчлөх шинж чанаргүй түүнийг чөлөөтөй нэвтрүүлдэг. Ийнхүү катион солилцох чадвар нь 0 байснаар бордоон дахь давснууд материалыар чөлөөтөй нэвчин өнгөрөх боломж олгоно. Мөн BASALTWOOL брендиийн Rockwool бүтээгдэхүүний ус шингээх чадвар бараг 0 тул хөрсгүй орчны үед ургамлыг усаар хангах хэрэгцээнд саад болохгүй. BASALTWOOL брендиийн Rockwool хавтангуудын авч үлдэж буй шим тэжээлийн бодис нь ургамалд очиж буйтай харьцуулахад ердөө 2% байна. Хүлэр намаг, модны үртэс, сүрэл зэрэг бусад органик орчин нь 65%-ийн ус шингээх шинж чанартай тул шим тэжээлийн бодисын бараг 24-28% нь материалд уусдагаас үүдэн тэдгээрийг ургамал тариалах орчинд ашиглах боломжгүй болдог. Харин BASALTWOOL брендиийн Rockwool-ийн онцгой сүвэрхэг бүтэц нь их хэмжээний шим тэжээлийн бодисыг ургамалд саадгүй нэвтрүүлэх боломж олгодог. Тэжээлийн бодис нэвчсэний дараа хавтан, блок, кубууд нь түргэн хугацаанд хангалттай хатаж амждаг бөгөөд сүвэрхэг бүтцийн 40-50% нь агаараар дүүрдэг. BASALTWOOL брендиийн Rockwool хавтангуудын шим тэжээлийн уусмалыг алгуур нэвчүүлэх чадвар нь ургацын эрүүл мэндийг хянах хэрэгсэл болдог ба ургамлын үндэслэх бүсэд хамгийн тааламжтай нөхцөл бүрдүүлж чаддаг.

Гайхамшигт BASALTWOOL брендиийн Rockwool-ын дулаан тусгаарлах чадвар нь манай орны эрс тэс уур амьсгалтай орчны газар тариаланд, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуйд ашиглах нь өндөр үр дүнтэй. Өвлийн улиралд жимсний мод, сөөг зэргийг хучиж хөлдөлтөөс хамгаалахаас гадна, мэрэгч амьтан шувуу зэргээс хамгаалах чухал ач холбогдолтой. Мөн хүнсний ногооны талбайг 15-20 см BASALTWOOL брендиийн Rockwool-ын хөвөнгөөр хучиж өвөлжвэл тухайн хөрс хөлдөхгүй бөгөөд хавар эрт тариалах боломжийг олгоно. Зуны улиралд тариалсан талбайг 2-3 см BASALTWOOL брендиийн Rockwool-ын хөвөнгөөр хучсанаар нарны хурц илч нь хөрсийг хэт халахаас хамгаалж хөрсөн дэхь чийглэгийг удаан хугацаанд хадгалж, хөрсийг тогтмол дулаан байлгаснаар үрсэлгээг хурдасгаж ургацыг нэмэгдүүлэх боломж олгоно. Ингэснээр ган гачигаас айх аюулгүй болно.




**BASALTWOOL®**



Давхар блокууд нь ургамлын үрийг тарих, үрслүүлэх нөхцөлд зориулагдсан бөгөөд илүү том ургуулах блокуудын өмнө хэрэглэгдэнэ. Энэ нь дангаараа салангид оршдог ургуулах систем юм. Давхар блокон давхартын V хэлбэртэй нүхнүүд нь агаарын солилцоог идэвхитэй явуулж үүний үр дүнд блокуудын дунд гэлтгүй дотор нь үрслэлт явагдах боломжтой болно. Бүх давхар блокууд 1,4 байх ба энэ нь 10x20 хэмжээтэй үрслүүлэх стандарт хавтгайд яг тохирсон байдаг.

Миниблок нь давхар блокын адил ургамлын үр тарих, үрслүүлэх орчинд хэрэглэгдэнэ. Миниблок нь квадрат хэлбэртэй, дөрвөн талдаа цагаан өнгийн хэт ягаан туяаны хамгаалалттай хуванцар боодолтой бөгөөд энэ нь чийгийг удаан барихад туслана. Эдгээр блокуудыг мөн гадна талын хуванцар боолтыг хуулан авч түүнээс арай том ургуулах блокын урьдчилан бэлтгэсэн нүхэнд суулган хэрэглэж болно. Миниблокуудыг тус бүр нь 15 блок агуулах 2 зүсмэл уутанд савлана.



Ургуулах блок-ийг шууд тариалалтад, мөн давхар блок, миниблокын үрслэлтийн ургуулах орчин болгон хэрэглэнэ. Жижиг блокуудад үндэслэж, нахиалсан ургамлыг том блок руу шилжүүлэн суулгахад нэгэнт үндэс нь цухийсан тул ургамал шилжүүлсэн газраа үндэслэн ургадаг. Блокууд тус бүрчлэн дөрвөн талдаа хэт ягаан туяаны хамгаалалттай цагаан боодолтой байх ба хуулан авч хэрэглэхэд тохиромжтой тузваар ороосон байна.

Блокын суурь нь үндсийг ялзрахаас сэргийлэх үүднээс бүрэн хаталт явагдах байдлыг хангахуйцаар суулгагдана. Хэрвээ ургуулах блок дахь ургамлын үндэс блокоос цухуйж эхэлбэл тухайн блокыг хавтангийн дээд талд байрлуулж үндсийг хавтан руу ургах боломжтой болгох хэрэгтэй. Эдгээр блокууд 3"урт, 4"өргөн, 4"өндөртөй гэх зэрэг өргөн сонголттой хэмжээтэй байна. Бүх ургуулах блокууд хэмжээгээрээ ялгагдах блокуудын зүсмэлүүд бүхий багц болгон савлана.



Хавтангууд нь ургамлын хураалтанд онцгой үүрэгтэй бүтээгдэхүүн юм. Хэрэглэхэд хялбар болгох үүднээс хэт ягаан туяаны хамгаалалттай полиэтилен уутанд савласан. Түүний онцгой бүтэц нь ургамлын үндэс түргэн хугацаанд хэмжээндээ хүртэл ургах боломж олгодог тогтвортой нөхцөл бүрдүүлж чаддаг. Ус болон шим бодис түгээлт нь тогтмол бөгөөд урьд өмнө байснаас илүүл том, үржил шимтэй ургац авах боломж олгоно. Хавтангуудын урт нь 36" өндөр нь 3" төрөл бүрийн өргөнтөй байна. 6"-ийн хавтан үндэс нь ургахад том зай шаардагдахгүй ургамалд тохирно. 8"-ийн хавтан хүчирхэг, бат бэх үндэс бүхий өргөст хэмх зэрэг нилээд идэвхитэй ургамал тариалантанд зориулагдсан. Хэрэглэхэд маш хялбар. Хавтангийн орой дахь нүхийг зүсч, шоонуудаа оройд нь байрлуулж, хатаалт явуулах зорилгоор хавтангийн хуванцар ёроол дахь цөөн тооны нүхийг онгойлгоно.



BASALTWOOL брендийн Rockwool үйрмэг хөвөнг дангаар нь ашиглахаас гадна ба органик гаралтай хольцод нэмэгдэл маягаар хэрэглэнэ. Цахирмаа болон хан боргоцойн төрлийн ургамлын хүлрийн орчин эвдрэх эсвэл хүлрийн орчинд ургамлын өвчлөлт түргэн тархаж буй тохиолдолд хүлрийг ус шингээгч шинж чанартай үйрмэг хөвөнгөөр солиход тохиромжтой байдаг. Хүлэр дээр түүний 20-50%-тай тэнцэх ус шингээгч үйрмэг хөвөнг нэмэхэд орчны ус агуулах чадвар болон агааржуулалт сайжирч ургамлын өсөлт түргэсдэг. Эдгээр BASALTWOOL брендийн Rockwool үйрмэг хөвөнг дангаар нь болон ус үл шингээгч үйрмэг хөвөнгтөй холимог байдлаар хэрэглэх нь орчны ус агаарын харьцаанаас хамаарна. Ус үл шингээгч үйрмэг хөвөнг агаажуулагч болгон хэрэглэнэ.

## BASALTWOOL брендийн Rockwool бүтээгдэхүүнүүд:

Үрсэлгээний шоо

Ургуулах блок

Үрсэлгээний хавтан

Үйрмэг хөвөн

Иж бүрэн багц

# BASALTWOOL®

